

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 116 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.МӨНХБААТАР ТАНАА

2024.02.25 № 07/604
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллагын аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудит журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж 5,104.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Санхүүгийн тайланд тусгагдсан 1,150.0 мянган төгрөгийн авлага, 10,667.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Худалдан авалтын цахим баримтын бүрдэл дутуу 52,368.1 мянган төгрөг,
- Ажилчдын цалинг нийгмийн даатгалын тайланд 1,834.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

- Холбогдох дээд газрын шийдвэргүйгээр 12,808.1 мянган төгрөгийн хөрөнгө орлогод
- бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй 143,067.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан холбогдох хууль, эрх зүйн актууд, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг” заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Балансын үзүүлэлт	Эхний Үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	130,769,097.43	89,213,260.95
33	АВЛАГА	-	938,196.42
33100	Бусад авлага	-	-
33102	Татвар, НДШ авлага	-	938,196.42
34	УРЬДЧИЛГАА	1,150,000.00	1,150,000.00
34700	Бусад урьдчилгаа	1,150,000.00	1,150,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	1,150,000.00	1,150,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,150,000.00	1,150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	129,619,097.43	87,125,064.53
35100	Түүхий эд материал	14,590,954.54	14,805,100.45
35110	Тусгай зориулалттай материал	10,497,217.54	12,026,779.45
35130	Эм боох материал	4,093,737.00	2,778,321.00
35400	Хангамжийн материал	115,028,142.89	72,319,964.08
35410	Бичиг хэргийн материал	6,542,460.00	7,196,620.00
35420	Аж ахуйн материал	87,651,748.15	50,815,430.87
35440	Түлш, шатах тослох материал	-	947,815.00
35450	Барилгын засварын материал	595,840.00	1,378,510.00
35460	Хүнсний материал	14,764,083.34	5,321,976.81
35470	Бусад хангамжийн материал	5,474,011.40	6,659,611.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,183,651,586.61	2,250,472,338.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,183,651,586.61	2,250,472,338.89
39200	Биет хөрөнгө	2,179,304,586.57	2,241,859,979.59
39201	Барилга, байгууламж	1,821,494,460.66	1,821,494,460.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,876,228.32)	(154,218,331.64)
39203	Авто тээврийн хэрэгсэл	227,015,468.00	227,015,468.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(104,537,598.03)	(134,168,648.20)
39205	Машин тоног төхөөрөмж	711,663,231.57	744,275,097.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(488,326,775.69)	(574,871,660.15)
39207	Тавилга, аж ахуйн, эд хогшил	168,658,752.59	208,249,000.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(110,597,148.75)	(123,151,131.06)
39217	Номын фонд	32,810,424.54	227,235,724.54
39300	Биет бус хөрөнгө	4,347,000.04	8,612,359.30
39301	Программ хангамж	19,426,837.00	25,151,025.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,079,836.96)	(16,538,665.70)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,314,420,684.04	2,339,685,599.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	10,667,687.59	10,667,687.59
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,667,687.59	10,667,687.59

Код	Балансын үзүүлэлт	Эхний Үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
41300	Өглөг	10,667,687.59	10,667,687.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,667,687.59	10,667,687.59
41313	ХХОАТ-ын өглөг	9,457,843.59	9,457,843.59
41314	ҮЭ-ийн өглөг	1,209,844.00	1,209,844.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,303,752,996.45	2,329,017,912.25
51	Засгийн газрын хувь оролцоо	2,303,752,996.45	2,329,017,912.25
51100	ЗГ-ын оруулсан капитал	888,053,349.02	888,053,349.02
51200	Хуримтлагдсан үр дүн	(217,242,285.59)	(191,977,369.79)
51210	Өмнөх үеийн үр дүн	(353,331,063.10)	(217,100,185.59)
51220	Тайлант үеийн үр дүн	136,088,777.51	25,122,815.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,632,941,933.02	1,632,941,933.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,314,420,684.04	2,339,685,599.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО (I)	1,472,186,013.00	1,597,027,755.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	306,001,013.00	222,223,555.91
1200	Нийтлэг татварын бус орлого	306,001,013.00	30,000.00
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого	306,001,013.00	30,000.00
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,000.00
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	306,001,013.00	
122	Тусламжийн орлого		222,193,555.91
122001	Хандив тусламж /дотоод/		222,193,555.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,166,185,000.00	1,374,804,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,166,185,000.00	1,374,209,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,166,185,000.00	1,374,209,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		595,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		595,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,336,097,235.50	1,571,904,940.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,336,097,235.50	1,571,904,940.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,268,109,836.81	1,446,619,473.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	890,858,852.79	1,028,113,594.00
210101	Үндсэн цалин	890,858,852.79	614,353,850.00
210102	Нэмэгдэл		339,321,875.00
210104	Урамшуулал		74,437,869.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,005,210.81	128,114,201.58
210201	Тэтгэврийн даатгал	77,052,685.09	80,788,268.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,732,410.01	10,375,330.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,985,928.01	16,510,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,566,744.34	1,398,139.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,667,443.36	19,042,273.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,947,923.00	30,457,809.00
210301	Гэрэл, цахилгаан	12,983,662.00	7,325,469.00
210302	Түлш, халаалт	17,717,351.00	18,620,976.00
210303	Цэвэр, бохир ус	9,246,910.00	4,511,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,309,747.18	12,213,329.80
210401	Бичиг хэргийн материал	8,714,163.98	2,354,140.00
210402	Тээвэр, шатахуун	4,297,563.20	2,435,585.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,347,500.00	2,348,916.00
210404	Ном, хэвлэл	150,600.00	

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	818,400.00	736,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,981,520.00	2,199,100.00
210408	Бараа материал акталсны зардал		2,139,028.80
2105	Нормативт зардал	32,850,741.54	31,203,171.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,756,721.00	414,416.00
210502	Хоол, хүнс	25,855,113.30	30,788,755.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,238,907.24	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,407,890.00	2,253,470.00
210604	Урсгал засвар	13,407,890.00	2,253,470.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,171,766.00	8,521,248.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,686,880.00	6,772,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	352,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,650.00	276,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,236.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,557,705.49	205,742,649.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	903,200.00	72,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,054,505.49	205,670,049.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,987,398.69	125,285,467.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,823,024.69	60,884,931.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,991,717.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,321,507.69	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,509,800.00	58,086,119.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,798,812.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	164,374.00	64,400,536.03
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	164,374.00	63,805,536.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		595,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	136,088,777.50	25,122,815.80
6	НИЙТ ҮР ДҮН (V)=(III)+(IV)	136,088,777.50	25,122,815.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨ ОРЛОГЫН ДҮН (I)	1,166,379,000.00	1,374,834,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,000.00	30,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	97,000.00	30,000.00
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,000.00	30,000.00
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,000.00
120042	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	97,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,166,282,000.00	1,374,804,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,166,282,000.00	1,374,209,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,166,282,000.00	1,374,209,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		595,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		595,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,165,801,900.00	1,364,676,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,801,900.00	1,364,676,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,090,892,309.00	1,225,875,013.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	882,872,800.00	1,028,113,594.00
210101	Үндсэн цалин	573,500,000.00	614,353,850.00
210102	Нэмэгдэл	232,120,100.00	339,321,875.00
210104	Урамшуулал	77,252,700.00	74,437,869.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,671,500.00	129,052,398.00
210201	Тэтгэврийн даатгал	74,736,700.00	81,726,465.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,733,700.00	10,375,330.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,995,642.00	16,510,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,738,158.00	1,398,139.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,467,300.00	19,042,273.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,947,923.00	30,457,809.00
210301	Гэрэл, цахилгаан	12,983,662.00	7,325,469.00
210302	Түлш, халаалт	17,717,351.00	18,620,976.00
210303	Цэвэр, бохир ус	9,246,910.00	4,511,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,259,900.00	12,698,786.00
210401	Бичиг хэргийн материал	2,871,010.00	1,642,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,091,000.00	3,383,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,347,500.00	2,348,916.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	818,400.00	818,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,106,990.00	4,506,110.00

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2105	Нормативт зардал	27,909,000.00	11,300,838.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,400,000.00	1,134,000.00
210502	Хоол, хүнс	24,179,000.00	9,836,838.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,330,000.00	330,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,860,000.00	3,091,140.00
210604	Урсгал засвар	4,860,000.00	3,091,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,233,886.00	8,995,848.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,749,000.00	7,247,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	352,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,650.00	276,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,236.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,137,300.00	2,164,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,439,300.00	798,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,698,000.00	1,366,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,909,591.00	138,801,186.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,745,217.00	74,400,650.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,991,717.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,243,700.00	13,515,719.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,509,800.00	58,086,119.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,798,812.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	164,374.00	64,400,536.03
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	164,374.00	63,805,536.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		595,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	577,100.00	10,158,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	577,100.00	10,158,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	577,100.00	10,158,000.00
22304	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	577,100.00	10,158,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨ ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(577,100.00)	(10,158,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	888,053,349.02	1,632,941,933.02	(353,331,063.10)	2,167,664,218.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Өмчид гарсан өөрчлөлт				-
8	Тайлант үеийн үр дүн			136,088,777.51	136,088,777.51
9	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	888,053,349.02	1,632,941,933.02	(217,242,285.59)	2,303,752,996.45
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			142,100.00	142,100.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,053,349.02	1,632,941,933.02	(217,100,185.59)	2,303,895,096.45
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
15	Өмчид гарсан өөрчлөлт				-
16	Тайлант үеийн үр дүн			25,122,815.80	25,122,815.80
17	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	888,053,349.02	1,632,941,933.02	(191,977,369.79)	2,329,017,912.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,180,900.00	1,310,433,663.97	64,747,236.03	95.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,375,180,900.00	1,310,433,663.97	64,747,236.03	95.3
210	Бараа, үйлчилгээний зардал	1,273,085,700.00	1,226,166,175.00	46,919,525.00	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,030,451,600.00	1,028,113,594.00	2,338,006.00	99.8
210101	Үндсэн цалин	616,349,000.00	614,353,850.00	1,995,150.00	99.7
210102	Нэмэгдэл	336,849,900.00	339,321,875.00	(2,471,975.00)	100.7
210103	Урамшуулал	77,252,700.00	74,437,869.00	2,814,831.00	96.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,613,000.00	129,052,398.00	5,560,602.00	95.9
210201	Тэтгэврийн даатгал	94,727,800.00	81,726,465.00	13,001,335.00	86.3
210202	Тэтгэмжийн даатгал	9,971,300.00	10,375,330.00	(404,030.00)	104.1
210203	ҮОМШӨ ний даатгал	7,977,000.00	16,510,191.00	(8,533,191.00)	207.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,994,200.00	1,398,139.00	596,061.00	70.1
210205	Эрүүл мэндийн даатгал	19,942,700.00	19,042,273.00	900,427.00	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,780,900.00	30,457,809.00	9,323,091.00	76.6
210301	Гэрэл, цахилгаан	11,960,200.00	7,325,469.00	4,634,731.00	61.2
210302	Түлш, халаалт	18,390,200.00	18,620,976.00	(230,776.00)	101.3
210303	Цэвэр, бохир ус	9,430,500.00	4,511,364.00	4,919,136.00	47.8
2104	Хангамж, бараа материалын зардал	18,610,200.00	13,856,786.00	4,753,414.00	74.5
210401	Бичиг хэрэг	2,099,000.00	1,642,300.00	456,700.00	78.2
210402	Тээвэр, шатахуун	6,490,000.00	3,383,400.00	3,106,600.00	52.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,387,200.00	2,348,916.00	38,284.00	98.4
210404	Ном, хэвлэл	287,000.00	-	287,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	851,100.00	818,060.00	33,040.00	96.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,495,900.00	5,664,110.00	831,790.00	87.2
2105	Нормативт зардал	17,105,900.00	11,158,738.97	5,947,161.03	65.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,332,000.00	1,134,000.00	1,198,000.00	48.6
210502	Хоол, хүнс	12,723,900.00	9,694,738.97	3,029,161.03	76.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,050,000.00	330,000.00	1,720,000.00	16.1
2106	Эд хогшил худалдан авах	15,730,800.00	12,061,140.00	3,669,660.00	76.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	6,730,800.00	3,061,140.00	3,669,660.00	45.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	10,276,900.00	8,995,848.00	1,281,052.00	87.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,128,500.00	7,247,300.00	881,200.00	89.2

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,164,000.00	1,000,000.00	164,000.00	85.9
210803	Даатгалын үйлчилгээ	473,400.00	352,098.00	121,302.00	74.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,200.00	276,450.00	18,750.00	93.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	215,800.00	120,000.00	95,800.00	55.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,516,400.00	2,164,600.00	4,351,800.00	33.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,784,000.00	798,600.00	2,985,400.00	21.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,732,400.00	1,366,000.00	1,366,400.00	50.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,095,200.00	74,542,750.00	27,552,450.00	73.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,095,200.00	74,542,750.00	27,552,450.00	73.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,116,800.00	13,657,819.00	24,458,981.00	35.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,058,400.00	58,086,119.00	972,281.00	98.4
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	4,920,000.00	2,798,812.00	2,121,188.00	56.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,375,180,900.00	1,310,433,663.97	64,747,236.03	95.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,375,180,900.00	1,310,403,663.97	64,777,236.03	95.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,375,180,900.00	1,310,403,663.97	64,777,236.03	95.3
310004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/		30,000.00	(30,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	68	79	(11.00)	116.0
620001	Удирдах ажилтан	2	1	1.00	50.0
620002	Гүйцэтгэх ажилтан	50	57	(7.00)	114.0
620003	Үйлчлэх ажилтан	16	21	(5.00)	131.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Захирал Д.Мөнхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага өглөгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2021 оны 02 сарын 02-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн эрхэм зорилго нь “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээг чанаржуулж, суралцагчдыг бодит чадвартай иргэн болгон төлөвшүүлэх”-д оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль үйл ажиллагаандаа дараах 4 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрүүл мэндийн хамгаалах эрсдэлгүй орчин бүрдүүлэх
- Судлагдахуун бүрээр суралцагч нэг бүрийн ялгаатай байдалд тулгуурласан сурлагын чанарт ахиц гаргах
- Багшийн хөгжлийг хангах, харилцаа хандлагыг өөрчлөх
- Багшийн судалгаа шинжилгээний арга барилд суралцуулахад дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Багш ажилчдын цалинтай холбоотой ажилласан жил, үндсэн цалин хөлс, зэрэглэл, албан тушаал, мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох зэргийг шинэчлэн баталсан

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус сургуулийн 2020 оны 09 сарын 02-ны захирлын А/12 тоот тушаалаар баталж мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

БШУЯ-ны сайдын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/29 тоот Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 96,344.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 15 зөвлөмж өгсөн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,571,904.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,719.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн ерөнхий боловсролын 116-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,264.9 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	938.2	938.2
Урьдчилгаа	1,150.0	1,150.0	-
Бараа материал	129,619.1	87,125.1	(42,494.0)
Үндсэн хөрөнгө	2,183,651.6	2,250,472.3	66,820.7
Нийт хөрөнгө	2,314,420.7	2,339,685.6	25,264.9
Өр төлбөр	10,667.7	10,667.7	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,303,753.0	2,329,017.9	25,264.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,314,420.7	2,339,685.6	25,264.9

Авлага дансны үлдэгдэл 938.2 мянган төгрөг болж 938.2 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,125.1 мянган төгрөг болж 42,949.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэсэн болон 2020 онд сургалтын үйл ажиллагаа явагдаагүйгээс бараа материалын худалдан авалт буурсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,250,472.3 мянган төгрөг болж, 66,820.7 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын данснаас хөрөнгийн ангиллын дагуу үндсэн хөрөнгөнд шилжиж ирсэн, төсвийн болон хөрөнгө оруулалтаар худалдан авсан хөрөнгө, мөн үнэ төлбөргүй хандив тусламжаар ирсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант

онд урсгал төсвийн хөрөнгөөр 10,158.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 92,297.3 мянга, хандиваар тусламжаар үнэ төлбөргүй ирсэн 128,306.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 25,151.0 мянган төгрөг болж 5,724.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр данс бүртгэгдсэн 10,667.7 мянган төгрөг нь тооцоо нийлсэн акт холбогдох баримтаар баталгаажаагүй өр төлбөр тусгагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,329,017.9 мянган төгрөг болж 25,264.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 238,312.8 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, түүнтэй холбогдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд байна. Энэ нь цалин урамшуулалд нэмэгдсэн өөрчлөлт болон тэтгэврийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой юм.

Өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн залруулгаар 142.1 мянган төгрөгөөр өмнөх оны хуримтлагдсан үр дүнг залруулсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,375,180.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,375,180.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,374,209.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,374,209.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 30.0 мянган төгрөг нийт 1,374,239.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,310,433.7 мянган төгрөгийг зарцуулж 63,805.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,310,403.7 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 7,898.6 мянга, тогтмол зардал 9,323.1 мянга, хангамжийн зардал 4,753.4 мянга, нормативт зардал 5,947.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 3,669.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 1,281.1 мянга, бараа ажил үйлчилгээний зардал 4,351.8 мянга, урсгал зардал 27,552.4 мянга, нийт 64,777.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл дутуу зарцуулагдсан нь Ковид-19 цар тахлын улмаас сургуулийн сургалтын үйл ажиллагаа зогсож, сурагчдын нормативт зардалууд болон цахилгаан, цэвэр бохир ус, шатахууны зардалууд хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас багш ажилчдын үдийн хоолонд зориулж 595.0 мянган төгрөгийн орлого орж ирсэн боловч зарцуулалт хийлгүй 595.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс 121 мэдээллийг илгээснээс 80 мэдээллийг хугацаанд нь тайлагнасан ба 41 мэдээллийн хугацааг хоцроож, 52 мэдээллийг байршуулаагүй зөрчлийн нийт дүн 269,354.9 мянган төгрөг байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,304,559.3 мянган төгрөгийн 27 зөрчлөөс 1,893.4 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт, 61,020.3 мянган төгрөгийн 19 албан шаардлага, 788,118.0 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг биелүүлж хэрэгжилт 34.8 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,893.4	2	1,893.4	-	-	100.0
Албан шаардлага	19	61,020.3	19	61,020.3	-	-	100.0
Зөвлөмж	6	1,241,645.6	5	788,118.0	1	453,527.6	36.5
Нийт дүн	27	1,304,559.3	26	851,031.7	1	453,527.6	34.8

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 562,931.1 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрснээс, 46,469.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 358.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 294,565.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 221,538.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын хоёр дансанд хамаарах 46,469.3 мянган төгрөгийн дүн бүхий 3 зөрчлийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материал дансанд бүртгэлтэй байсан 41,729.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгүүлсэн;
2. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг буруу тогтоосноос үүссэн 4,520.0 мянган төгрөгийн алдааг нэмж тооцуулан

3. Хандиваар үнэ төлбөргүй ирсэн орлогод авагдаагүй 220.0 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг орлогод бүртгүүлж тус тус залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 516,461.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил үлдсэнээс 358.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 294,565.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд нэр бүхий хоёр ажилтны цалинг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнаж, 6 болон 7 дугаар саруудын нийгмийн даатгалын тайланг 358.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Албан шаардлага

1. Тухайн байгууллага харуулын орон тооны ажилтантай боловч гэрээт харуул хамгаалалтын “Сүлдэт бамбай секьюрити сервис” компанитай давхар гэрээ хийж 5,104.0 мянган төгрөгийг төсвөөс гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, гэсэн заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1 стандартын санхүүгийн тайлангийн толилуулга заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. Төсөвлөгдсөн цалингийн зардлаас ажлаас халагдсан ажилчдын шүүхийн шийдвэрийн нөхөн олговор 15,904.6 мянган төгрөгийг олгосон Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн, 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, УСНББОУС 11-ын нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс 121 мэдээллийг илгээснээс 80 мэдээллийг хугацаанд нь тайлагнасан ба 41 мэдээллийн хугацааг хоцроож, 52 мэдээллийг байршуулаагүй зөрчлийн нийт дүн 269,354.9 мянган төгрөг байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4. БШУЯ-наас 4,201.8 мянган төгрөгийн бага ангийн нэг сурагч суух зориулалттай 54 ширхэг ширээ, сандал нийлүүлэгдсэн нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний

сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, УСНББОУС 1 стандартын санхүүгийн тайлангийн толилуулга заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 221,538.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар авч үзвэл зохих дараах асуудлууд байна гэж үзлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхийг шалгах;
- Үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, шинээр авсан болон актлах хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон БШУЯ-ны шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн эсэх
- Анхан шатны цахим баримтын иж бүрдлийг хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх
- Шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу тогтмол цаг хугацаанд нь мэдээлсэн эсэх

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмблэн үзүүлэв. Үүнд:

1. Цалин, нийгмийн даатгалын тайлантай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

2 ажилтны бодогдсон цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын тайланд 1,476.6 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим "5.1.4. үнэн зөв байх, Нийгмийн даатгалын тухай хуулийн "17.1.1. цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогыг албан татварын тайлан буруу дүнгээр тайлагнагдсанаар ажилчдын төлсөн татвар шимтгэлүүд дутуу тооцогдож хохирох эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж:

Ажилчдын цалинг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа цалингийн мэдээллийг сайтар хянаж байх, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох суутгал, шимтгэлийг үнэн зөв тооцож тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Дахин ийм алдаа гаргахгүй ажиллана.

2. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт:

Анхан шатны хүчин төгөлдөр бус и-баримтгүй 52,368.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь "НББ-н тухай хуулийн 3.1.3 "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ тухай хуулийн 4.1.14. "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг;" зөрчиж байна.

2.2. Эрсдэл:

Зөвхөн нэхэмжлэх дээр бичигдсэн дүнгээр гүйлгээ худалдан авалтын гүйлгээг хийж байгаа нь "НББ-н тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" тухайн худалдан авалтыг тухайн бараа ирээгүй байх дутуу ирэх баталгаажихгүй байх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: И баримтаа нөхөж авах ба цаашид ийм алдаа гаргахгүй ажиллана.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал:

3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тайлагнагдсан 1,150.0 мянган төгрөгийн авлага, 10,667.7 мянган төгрөгийн өглөг нийт 11,817.7 мянган төгрөгийн үлдэгдэл нь тооцоо нийлсэн акт болон баримтаар нотлогдохгүй, эзэн холбогдогчгүй мэдээлэл тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл. 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, баталгаагүй үлдэгдлээр зардал гарах эрсдэлтэй.

3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд баталгаажсан дүнгээр авлага, өглөгийг илэрхийлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Бид авлага өглөг үүсгэхгүй байхаар ажиллаж байна.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

4.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй, элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 143,067.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 1.2 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.2. Эрсдэл:

Төрийн өмчийг зөвшөөрөлгүй акталж устгах, хөрөнгийн устгал хийгээгүйгээс хөрөнгө холилдох буцаж тоологдох буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

4.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журамд заасны дагуу зохих зөвшөөрлийг авч акталж устгах, борлуулах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зохих зөвшөөрлийг журам зааврын дагуу авч ажиллана

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

5.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр 12,808.1 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 2.1 Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй.

5.2. Эрсдэл:

Хандив тусламжаар ирсэн хөрөнгө эзэнгүйдэх алга болох, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй орлого авснаар, төрийн өмчин тооллого хяналтаар зөрчилд торгууль ногдох эрсдэлтэй

5.3. Өгсөн зөвлөмж:

Хандив тусламжаар ирсэн болон хөрөнгө оруулалтаар ирсэн үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам болон БШУЯ-ны зохих зөвшөөрлийн дагуу үндсэн хөрөнгөнд авч бүртгэлд тусгах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Дахин ийм зөрчил гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/159/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Анхан шатны хүчин төгөлдөр бус и-баримтгүй худалдан авалт хийсэн	52,368.1	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
2	Төсөвт тусгагдаагүй зохих зөвшөөрөлгүй харуул хамгаалалтын зардал гаргасан	5,104.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
3	Үлдэх өртөггүй ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг актлаагүй	143,067.9	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр хөрөнгө бүртгэлд тусгаж тайлагнасан	12,808.1	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
5	Боловсролын яамнаас тухайн сургуулийн стандартад нийцээгүй ширээ, сандал нийлүүлсэн	4,201.8	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
6	Тайланд тусгагдсан авлага болон өглөгийн дансны үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй	11,817.7	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
7	Тайлант хугацаанд ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 3 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгосон.	15,904.6	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
8	Нэр бүхий 2 ажилтны цалинг нийгмийн даатгалын тайланд дутуу зөрүүтэй дүнгээр тайлагнасан.	1,476.6	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
9	Тооцсон цалинг Нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан байна.	358.1	Акт	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
10	Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс 121 мэдээллийг илгээснээс 80 мэдээллийг хугацаанд нь тайлагнасан ба 41 мэдээллийн хугацааг хоцроож, 52 мэдээллийг байршуулаагүй байна.	269,354.9	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Б.Уламбаяр
ДҮН		516,461.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 дугаар сарын 15

№ 64/А0160058

Улаанбаатар хот

СЯГ-2021/159/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий хоёр ажилтны цалинг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнаж, 6 болон 7 дугаар саруудын нийгмийн даатгалын тайланг 358,095.00 /гурван зуун тавин найман мянга ерэн таван/ төгрөгөөр суутган авсан боловч дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий хоёр ажилтны цалинг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан 358,095 /гурван зуун тавин найман мянга ерэн таван/ төгрөгийг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн төрийн сангийн 100200690000 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Уламбаяр нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН


ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 268/АО160058

Улаанбаатар хот

САГ- 2021/159/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас нийлүүлсэн 4,201,800.00 /дөрвөн сая хоёр зуун нэг мянга найман зуун/ төгрөгийн бага ангийн нэг сурагч суух зориулалттай 54 ширхэг ширээ, сандлын хамт нийлүүлэгдсэн нь харааны бэрхшээлтэй хүүхдийн сургалтын шаардлагад нийцэхгүй байна.

Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас нийлүүлэгдсэн сурагч сандал, ширээг тусгай хэрэгцээт хүүхдийн шаардлагад нийцүүлэн солиулж, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э.Энхжаргалд даалгав.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 269/АД160058

Улаанбаатар хот

СЭГ- 2021/159/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 3 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 15,904,632.00 /арван таван сая есөн зуун дөрвөн мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэр бүхий 3 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт олгосон 15,904,632.00 /арван таван сая есөн зуун дөрвөн мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгийн төрд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлж, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э.Энхжаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 270/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/159/СТА-ТЦЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тухайн байгууллага харуулын орон тооны ажилтантай боловч гэрээт харуул хамгаалалтын “Сүлдэт бамбай секьюрити сервис” компанитай давхар гэрээ хийж 5,104,000.00 /таван сая нэг зуун дөрвөн мянган/ төгрөгийг төсвөөс гаргасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Уламбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 071/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/159/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 173 мэдээллээс 41 мэдээллийг хугацаа хоцроож, 269,354,900.00 /хоёр зуун жаран есөн сая гурван зуун тавин дөрвөн мянга есөн зуун/ төгрөгийн 52 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Уламбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА